



НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын өдөрлөгийг зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийн зардлыг гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автомашингүй өдөр” арга хэмжээний хүрээнд Биеийн тамир, спортын өдөрлөгийг 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. “Автомашингүй өдөр” арга хэмжээний хүрээнд Биеийн тамир, спортын өдөрлөгийг зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийн зардал болох 1,700,000 (Нэг сая долоон зуун мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Нийтийн Биеийн тамирын зардлаас гаргахыг Нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Өдөрлөгийн урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 438 дугаар тушаалын хавсралт



Биеийн тамир, спортын өдөрлөгийг зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийн төсөв

№	Зарцуулах үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Үзель, хөгжим	нүүр	4	250,000	1,000,000
2.	Бүжгийн тавцан, карказ	ш	10	35,000	700,000
Дүн					1,700,000